

- ✓ **Алсын хараа:** Монгол эмч, мэргэжилтний ур чадварыг Дэлхийд зөвшөөрүүлнэ.
- ✓ **Эрхэм зорилго:** Сонгдо эмнэлэг нь 2027 он гэхэд GHA стандартыг хангасан үндэсний тэргүүлэгч эмнэлэг болно.
- ✓ **Үнэт зүйлс:**

**ҮНЭТ ЗҮЙЛ НОМЕР-1: СОНГДО-СОГ СЭТГЭЛГЭЭ**  
(*Бид харилцан итгэлцэлтэй, хамтран ажилладаг, эвсэг хамт олон*)

➤ *Бид баримтална:*

- i. Багийн нэгдсэн зорилгод хүрэхийн тулд багийн гишүүн гэдгээ ухамсарлана.
- ii. Сайн сонсогч бас зөвлөгч байна
- iii. Хоорондын уялдаа холбоо сайтай, харилцан хүндлэлтэй ажиллана.
- iv. Асуудлыг олон талаас нь хэлэлцэн олонхын саналд үндэслэн шийдвэр гаргана.
- v. Ажлаа чин сэтгэлээсээ гүйцэтгэнэ.

➤ *Бид үл зөвшөөрнө:*

- i. Багийн шийдвэрийг үл хүндэтгэх
- ii. Ажилдаа хувийн ашиг сонирхлоор хандах
- iii. Идэвхгүй хойрго байдал
- iv. Өөрийн үзэл бодлыг бусдад тулгах
- v. Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх
- vi. Сөрөг хандлага түгээх

**ҮНЭТ ЗҮЙЛ НОМЕР-2: ЧАДВАРЛАГ МЭРГЭЖИЛТЭН**  
(*Бид өндөр мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвартай*)

➤ *Бид баримтална:*

- i. Шинэчлэлийг эрэлхийлэгч, өөрчлөлтийг дэмжигч байна
- ii. Тэргүүн туршлагыг нэвтрүүлэгч, мэдлэгээ хуваалцагч байна
- iii. Хамтрагчаа тасралтгүй сургаж чадавхижуулагч байна

➤ *Бид үл зөвшөөрнө:*

- i. Ажилдаа мэргэжлийн бус хандах
- ii. Бусдын нөлөөнд автах
- iii. Аливаа эрсдэлийг тоохгүй байх

**ҮНЭТ ЗҮЙЛ НОМЕР-3: ИННОВАЦИ, ХӨГЖИЛ ДЭВШИЛ**  
(Бид шинэ технологи нэвтрүүлж, тэмүүлэлтэй хөгжинө)

➤ *Бид баримтална:*

- i. Шинэ санал-санаачлага гаргах, дэвшилтэт бүхнийг эрэлхийлэгч байна
- ii. Сүүлийн үеийн технологийг анхдагчаар нэвтрүүлж, үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллана.
- iii. Гадаад болон дотоодод шилдэг технологид суралцах

➤ *Бид үл зөвшөөрнө:*

- i. Батлагдаагүй судалгаа шинжилгээг эмнэлгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх
- ii. Инноваци шинэчлэлтийг эсэргүүцэх
- iii. Байнгын суралцагч байхаас татгалзах

**ҮНЭТ ЗҮЙЛ НОМЕР-4: ЭНЭРЭЛ, ХҮНДЭТГЭЛ**  
(Бид энэрэнгүй, хүндэтгэлтэй, ёс зүйтэй хандана)

➤ *Бид баримтална:*

- i. Эмчлүүлэгч, үйлчлүүлэгчийг өөрийн гэр бүлийн гишүүд мэт хандан чин сэтгэлээсээ үйлчилнэ.
- ii. Нийгмийн анги давхарга, баян ядуу, арьс өнгө болон шашны итгэл үнэмшлээр ялгаварлан гадуурхах үзлээс ангид байна.
- iii. Эмчлүүлэгч, үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг чандлан нууцлана.
- iv. Эмчлүүлэгч, үйлчлүүлэгчийн үнэт зүйлсийг хүндэтгэн үзнэ.

➤ *Бид үл зөвшөөрнө:*

- i. Хувийн ашиг сонирхлоор эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх
- ii. Эмчлүүлэгч, үйлчлүүлэгчидэд шаардлагагүй тусламж үйлчилгээг санал болгох
- iii. Эмчлүүлэгч, үйлчлүүлэгчийг төөрөгдүүлж худал мэдээлэл хүргэх

**ҮНЭТ ЗҮЙЛ НОМЕР-5: ШИЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ**  
(Бид чанартай, түргэн шуурхай, хариуцлагатай үйлчилнэ)

➤ *Бид баримтална:*

- i. Эмчлүүлэгч, үйлчлүүлэгчийн хүлээлтийг давуулан биелүүлэхийг зорин ажиллана.
- ii. Чанар аюулгүй байдлыг ханган ая тухтай, эрүүл орчин нөхцөл бүрдүүлэн ажиллана.
- iii. Бүх шатанд сэтгэлд нийцсэн үйлчилгээг үзүүлэхийг зорино.

- iv. Эмчлүүлэгч, үйлчлүүлэгчийн сайн зөвлөх байна
- v. Өөрийн ажилдаа халдвар хамгааллыг дэгийг чандлан сахина.

➤ *Бид үл зөвшөөрнө:*

- i. Эмчлүүлэгч, үйлчлүүлэгчийг ялгаварлан гадуурхах
- ii. Эмчлүүлэгч, үйлчлүүлэгчийг чирэгдүүлэх
- iii. Эмчлүүлэгч, үйлчлүүлэгчийг үл хүндэтгэх

**СОНГДО ЭМНЭЛГИЙН УРИА: ТӨГС ОНОШЛОГОО, СОНГОДОГ  
ЭМЧИЛГЭЭ**

**УЛААНБААТАР СОНГДО ЭМНЭЛГИЙН ЭРХЭМ АЖИЛТАН ТАНД  
АЖЛЫН АМЖИЛТ ХҮСЭЕ.**